



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/66

Хажуу шинэ-Ус

Дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/125 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/366 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны 6 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулан малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Гүнсэнтүг), 2 дугаар багийн Засаг дарга (Г.Батчулуун), 3 дугаар багийн Засаг дарга (Б.Даваасүрэн) нарт үүрэг болгосугай.

2.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад ямаа, төл малыг бүрэн хамруулж ажиллахыг Угтаал чандмань хоршоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Д. Амгалан)-д даалгасугай.

3.Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, шуурхай үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавин ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482301066